

6

ШИНЭ УЛС ТӨРИЙН МАКРОЭКОНОМИКС

Л.Эсмэдэх, З.Манлайбаатар, Т.Оюунбаатар

Улс төрийн гажуудал ба макро эдийн засгийн байдал

Эдийн засгийн бодлогын сонголтоос үүдэлтэй эдийн засгийн ерөнхий байдалд улс төрийн үзүүлэх нөлөө илэрхий учраас эдийн засагчид эдийн засаг болон улс төрийн системийн хоорондох хамаарлыг сонирхон судлах болов. ХХ зууны сүүлийн хорин таван жилийн туршид улс төр ба макроэкономиксийн хоорондох харилцааны янз бүрийн хэлбэрийн тухай судалгаа эрчимжиж байгаа бөгөөд “шинэ улс төрийн макроэкономикс” гэж нэрлэгдэх шинэ салбар буй болжээ. Судалгааны энэ чиглэл макроэкономикс, нийтийн сонголтын онол, тоглоомын онолын уулзвар дээр үүссэн байна. Ид хөгжин цэцэглэж буй судалгааны энэ салбарт эдийн засгийн шинжилгээний орчин үеийн арга хэрэгслийг ашиглан төрийн бодлогын талаарх судалгааг хийж байна. Бизнесийн мөчлөг, инфляц, ажилгүйдэл, тогтворжуулах бодлогод үзүүлэх улс төр, эдийн засгийн хүчин зүйлс болон дарангуйлал, ардчилал, тэгш бус байдал ба эдийн засгийн өсөлт, тогтворгүй байдал ба зөрчил, ужиг төсвийн алдагдал, олон улсын интеграц, үндэстний хэмжээ зэрэг асуудлын хоорондох хамаарал нь эдийн засагчдын тухайлан сонирхдог сэдэв юм. Энэ салбарт гол хувь нэмэр оруулж, онолын болон эмпирик судалгаагаар баяжуулж буй судлаачид нь Дэрон Эйсмоглу, Алберто Алесина, Алан Дрезен, Бруно Фрэй, Дуглас Хиббс, Уильям Нордхаус, Дуглас Норт, Манкур Оолсон, Кеннет Рогофф, Фрэдрик Шнайдер, Андрей Шлайфер нар юм

Бодлогын сонголт дахь улс төрийн нөлөө

Кейнс капитализмыг мэдэгдэж буй бусад бүх тогтолцооноос эдийн засгийн илүү үр ашигтай үр дүнд хүрдэг гэдэгт итгэлтэй байжээ. Гэхдээ капитализмд ч гэсэн төрийн оролцоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага гардаг. Сонгодог эдийн засагчид нийт эдийн засагт хэлбэлзэл гарахыг үгүйсгэдэггүй боловч үнийн механизм нь өөрийгөө

засварлаж, тодорхой хугацаанд систем өөрийгөө сэргээн бүрэн ажил эрхлэлтэд хүрнэ гэдэгт итгэлтэй байдаг. 1920-иод оны дунд үе гэхэд Кейнс тогтвортой байдал ердийн хэм хэмжээ болсон капиталист эдийн засгийн талаарх сонгодогуудын “зөнд нь орхих” философид эргэлзээтэй ханддаг болсон байв. Кейнс капитализмд ухаалаг менежмент хэрэгтэй гэж үзэж байсан нь практик утгаараа “эдийн засгийг бүхэлд нь аюул сүйрлээс аврах жор”-ын тухай ярьж байсан юм. Хуучин кейнсийн үзэл нь сүйрэл авчирсан “их хямрал”-аас эхтэй бөгөөд зах зээлийн эдийн засгийг угийн тогтворгүй гэж үздэг. Энэхүү тогтворгүй байдал нь ажил эрхлэлт, үйлдвэрлэлд хэлбэлзэл үүсгэж, нийгмийн сайн сайхан байдлыг бууруулдаг. Ийм учраас хуучин кейнсчүүд энэхүү тогтворгүй байдлыг мөнгөний болон сангийн дискрет бодлогоор залруулж болно гэж үздэгийг бид мэднэ. Хуучин кейнсийн энэ үзэл санааны цаана засгийн газар тогтвортой байдлыг л эрмэлздэг хэмээх суурь нөхцөл бий.

Энэхүү гэнэн суурь нөхцөлд эргэлзээтэй хандсан анхны эдийн засагчдын нэг нь Микал Калецки байв. Тэрбээр капиталистуудын эрх ашгийг хамгаалдаг тууштай дэмжигчийн засгийн газар нь ажилчдын хэлэлцээрт орох байр суурь улам бэхжихээс сэргийлж, эдийн засгийн зогсонги байдлыг зориуд үүсгэдэг болохыг Маркс-Кейнсийн загвараар харуулжээ. Хэрэв удаан хугацаанд бүрэн ажил эрхлэлттэй байвал ажилчид “том толгойтой” болж, хэлэлцээр хийхэд амаргүй болно. Калецкийн загвараар бол төлөөллийн бус улс төрийн механизмын дүнд капиталистуудын сонирхол давамгайлснаар улс төрийн бизнесийн мөчлөг үүсдэг. Харин Эйкермэн 1947 онд хожмын үйл явдлын өрнөлийг урьдаас таамаглаж үзээд, сонгуулийн мөчлөг нь эдийн засгийн бодлогод нөлөөлөн нийт эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэж болзошгүй гэсэн санаа дэвшүүлжээ. Энэ нь улс төрчид нийгмийн сайн сайхны төлөө л зүтгэнэ, орлогын урсгал эргэлтэд төр экзоген байдлаар оролцоно гэсэн нөхцөл дэвшүүлдэг Кейнсийн уламжлалт загваруудаас мэдээж ялгаатай байв. Харродын дүгнэснээр, Кейнс бол оюунлаг язгууртнуудаас сонгогдсон гэгээрсэн хүмүүс л эдийн засгийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх ёстой гэж үздэг элитийн онолч ажээ. Эдгээр урьдач нөхцөл нь эдийн засгийн бодлого нийтийн ашиг сонирхлын төлөө хуульчлагддаг хэмээх Кейнсийн сэтгэлгээний тусгал юм. Нийгмийн сайн сайхныг сахин хамгаалагч мэт аашлах төрийн ийм буянтай дарангуйлагчийн дүр төрхөд эдийн засагчид улам бүр эргэлзсээр иржээ. Тухайлбал, нийтийн сонголтын онолчид сонгуулиар гарч ирсэн улс төрчид нийгмийн цэвэр ашиг тусыг хамгийн их байлгах бодлого явуулдаг гэсэн суурь нөхцөлд эргэлзээтэй ханддаг. Кейнсийн хувьсгалын эхэн үед буюу 1930-аад оны эцэс 1940-өөд оны эхээр Жозеф Шумпитэр үүнийг тодруулж, капиталист ардчилалд улс төрчид сонгогдохын төлөө өрсөлддөг учраас бодлогын шийдвэр болон үр дүнд нөлөөлөх нь гарцаагүй гэж үзэж байв. Жишээ нь, нийтийн сонголтын хандлагаар авч үзвэл кейнсийн экономикс хямралын аюулыг бууруулах арга зам нь төсвийн алдагдал гэсэн санаанд ач холбогдол өгснөөрөө аж үйлдвэрийн ардчиллын санхүүгийн зарчмыг үндсээр нь сулруулсан юм. “Улс төрчид сонгогчдод таалагдах боломжийг байнга эрж хайдаг ардчилсан тогтолцоонд Кейнсийн бодлогын зөвлөмж зайлшгүй гажуудалд хүргэнэ” гэж Бьюкенен тэргүүтэй судлаачид үздэг. Сонгогчид засгийн газрыг үе хоорондын төсвийн хязгаарлалттай тулгарч байгааг ойлгохгүй учраас өрөөр санхүүжсэн зарчмын

хөтөлбөрүүд нь ирээдүйн татварын өр гэдгийг дутуу үнэлдэг. Өөрөөр хэлбэл, сонгогчид “санхүүгийн илбэнд” автдаг аж. Төсвийг мөчлөгийн эсрэг тэнцвэржүүлэх Кейнсийн зорьж байсан зарчмаар бус чиг үүргийн санхүүжилтийн тухай Абба Лернерийн зарчмаар аваад үзвэл, эдийн засгаар аргалж сонгуульд ялах гэсэн оролдлого нь байнга төсвийн алдагдал авчрах тул тогтворжуулах бодлого гажуудалд хүргэдэг байна. Төсвийг алдагдалд оруулах нь өрөөр дамжуулан ирээдүйн засгийн газрын бодлогод нөлөөлөх гэсэн одоогийн засгийн газрын стратегитэй үйл хөдлөл ч байж болон юм.

Энэ бүхнийг харгалзаж үзээд макро эдийн засагчид улс төрчдийг “улс төрийн ашиг сонирхлын үүднээс эдийн засагт манипуляц хийж” болзошгүй гэж хардаж байх ёстой болж байна. Неоклассик улс төрийн эдийн засгийн бүтээлүүдэд төрийн оролцоог экзоген биш, зарим талаараа эндоген бөгөөд бодлого нь нийгмийн янз бүрийн сонирхлыг тусгадаг гэж үзэх болжээ. Энэ нь мэдээж шинэ үзэл биш гэдэг нь Токвиллийн алдарт *Америкийн ардчилал* зохиолын дараах тайлбараас харагдана:

Ерөнхийлөгчийн эн тэргүүний зорилго нь дахин сонгогдох хүсэл байдаг ба сонгууль дөхөхөд хувийн сонирхлоо нийгмийн эрх ашгаас дээгүүр тавьдаг гэдгийг хүлээн зөвшөөрөхгүйгээр Америкийн Нэгдсэн Улсад болж буй жирийн хэрэг явдлыг авч үзэх боломжгүй (Tocqueville, *Democracy in America*, 1835).

Хэдийгээр Кейнс ихэнх улс төрчдийг тун доогуур үнэлдэг байсан ч тэр үед улс төрийг сонгуулийн санал худалддаг зах зээл гэж ойлгох тухайд санаанд нь буухгүй байжээ. Кейнс оюун санаандаа бодлого боловсруулах үйл явцын нэгэн шугаман загварыг төсөөлж байсан бөгөөд түүндээ эдийн засагчдын үүргийг эрүүл эдийн засгийн шинжилгээнд суурилсан зөвлөгөө өгөх, таамаглах, улс төрчдийг хариуцлагатай бодлого боловсруулахад чиглүүлэх гэж үзэж байв. Харин улс төрчид нь эдийн засгийн гол асуудлын үр дүнтэй шийдийг хайдаг учраас эдийн засагчдын зөвлөсний дагуу нийгмийн сайн сайхан байдлыг хамгийн их байлгах арга хэмжээг шууд хэрэгжүүлнэ гэж үздэг. Бодлого боловсруулах үйл явцын талаарх эдийн засагчдын уламжлалт үзлийг зураг 1-ийн дээд хэсэгт харуулав.

Бодлого боловсруулах уламжлалт хандлага нь Тимберген, Тэйл нарын 1950-иад онд боловсруулсан уламжлалт хандлагад үндэслэдэг. Жишээлбэл, Тэйлийн анх бий болгосон уламжлалт оновчлолын хандлагад бодлого боловсруулагчдыг “нийгмийн сайн санаат төлөвлөгч” гэж загварчлан, түүний цорын ганц зорилго нь нийгмийн сайн сайхан байдлыг дээд зэргээр хангах явдал гэж үздэг. Тиймээс эдийн засгийн бодлогын шинжилгээний уламжлалт норматив хандлагаар авч үзвэл төр экзоген хүчин зүйл юм. Төрийн ганц сонирхол нь хамгийн сайн боломжит үр дүнд хүргэхээр эдийн засгийг удирдах. Эдийн засгийн бодлогын шинжилгээг тодорхой хязгаарлалт бүхий максимумчлалын бодлогод хураангуйлж болно гэсэн үг.

Шинэ улс төрийн эдийн засагчдын үүднээс харвал бодлого боловсруулагчид эдийн засагчдын зөвлөгөөг дагахаас илүүтэйгээр нийгэм-төрд төвлөрсөн нөлөө бүхий хүчнүүдийн аясыг дагадаг. Иймээс эдийн засагчдын өгөх зөвлөгөөнд суурилсан онолын үзэл санаа, бодлогын зөвлөмж ямар нэг улс төрийн системээр дамжина. Хэрэв тухайн нийгэм олон янзын санаа бодолтой хүмүүсээс бүрэлдэж

байгаа бол тэрхүү улс төрийн систем ашиг сонирхлын зөрчлийн тэнцвэрийг илэрхийлэх ёстой. Нийгэм төвт хандлагаар авч үзвэл, янз бүрийн бүлгүүд өөрсөддөө шууд ба шууд бусаар ашигтай бодлогыг “нийлүүлэхийг” бодлого боловсруулагчдаас шаарддаг. Харин нео-марксистууд нөгөө л ангийн тэмцэл, капиталистуудын эрх мэдлийг голлон авч үздэг бол шинэ улс төрийн эдийн засгийн зохиол бүтээлд сонирхлын бүлэг (жишээ нь малчид), улс төрийн нам, сонгогчдын үзүүлэх нөлөөг онцлон авч үздэг. Төр төвтэй хандлагаар авч үзвэл технократын үүргийг онцлох нь “сайн санаат дарангуйлагч”-ийн тухай суурь нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаатай адилхан ажээ. Харин шинэ улс төрийн эдийн засаг бодлого боловсруулагчдад түшмэлүүд ба бүс нутгийн ашиг сонирхлын зүгээс ирэх нөлөөг онцолдог.

Бодлого боловсруулах үйл явцын уламжлалт хандлагыг Тони Киллик олон жилийн өмнө “Хөгжлийн хөтөлбөрийн боломж”-ийн тухай шүүмждээ нэгтгэн дүгнэжээ.

Эдийн засагчид улс төрийн рационал оролцогчийн загварыг хэрэглэдэг. Уг загварт нийгмийн төлөө санаа тавьдаг, мэдлэг чадвартай улс төрчдөөс төр засаг бүрдэх ба тэд тодорхой, нэгдсэн зорилго дэвшүүлдэг, үндэстний эрх ашгийн төлөө оновчтой үр дүнд хүрэх бодлого сонгодог, алсыг харах чадвартай гэж үздэг. Хуваагдал, ялгаа багатай нийгэмд засгийн газар нь тогтвортой, эрх мэдлийг төвлөрүүлэн барьдаг, харьцангуй нэр хүндтэй эрх мэдэлтнүүдтэй, ерөнхийдөө тухайн бодлогын шийдвэрээс хүсч буй үр дүндээ хүрэх чадвартай.


Бодит байдал дээр нийгэм шашин шүтлэг, арьс өнгө, хэл соёлын хувьд ялгаатай, газарзүйн бүс нутагт хуваагдсан, ялангуяа орлого, баялгийн хувьд туйлын тэгш бус байдаг. Иймээс төр ашиг сонирхлын тэнцвэр байнга өөрчлөгдөхийн хэрээр ерөнхий ашиг сонирхол гэхээсээ тухайн ашиг сонирхлыг тусгасан зөрчлийг шийдэх бодлогыг байн байн авч үздэг. Ийм ертөнцөд “үндэсний сонирхол”, “нийгмийн сайн сайхан байдлын функц” зэрэг ойлголт нь практик агуулга багатай юм. Нийгмийн хуваагдалтай нөхцөлд шийдвэр гаргалт нь оновчлолыг эрж хайхаасаа илүүтэй асуудлыг тэнцвэржүүлэхэд чиглэдэг. Зөрчлийг шийдвэрлэх үйл явц нь дээд зэргийн өсөлт гэхээсээ нийгмийг тайвшруулж, эрх мэдлээ хадгалж үлдэхэд голлон анхаарна.

Улс төр-эдийн засгийн хамаарлыг загварчилдаг шинэ улс төрийн макроэкономикст эдийн засаг ба улс төрийн хүчний харилцан үйлчлэлийн гол төвд засгийн газрыг авч үздэг. Засгийн газрыг ийнхүү эндоген байдлаар авч үзсэнээр норматив хандлагаар томъёолсон эдийн засгийн бодлогыг сайн сайхан байдлыг аль болох нэмэгдүүлэх бодлого гэж үзэх нь “логикийн хувьд боломжгүй” болно. Эрх барьж буй улс төрчид эдийн засгийн бодлогыг сонгох болон хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд тэдний үйл хөдлөлийг улс төрийн системийг бүрдүүлж буй янз бүрийн институцийн хязгаарлалтаар тодорхойлно. Иймээс макро эдийн засгийн үйл явц болон бодлогын шинжилгээний улс төрийн эдийн засгийн хандлага нь улс төрчид, тэдний бодлогын сонголтод нөлөөлөх хүчин зүйлсийг онцлон авч үздэг.

Төрийн үүрэг

Төр юу хийдэг болон юу хийдэггүй нь эдийн засгийн өсөлт, тогтворжилтод чухал нөлөөтэй юм. Сангийн, мөнгөний, валютын ханшны бодлого, олон улсын худалдаа, өрсөлдөөн, зохицуулалт, хөдөлмөрийн зах зээл, боловсрол, эрүүл мэндэд чиглэсэн бодлогууд болон өмчийн эрх гэх мэт институцийг хангах нь бүхэлдээ эдийн засгийн ерөнхий байдалд чухал нөлөө үзүүлдэг. XIX зууны туршид эдийн засаг дахь төрийн үүрэг ДНБ-д эзлэх төрийн зардлын хувиар хэмжихэд 10 орчим хувьтай л байдаг байв. Гэтэл 1996 он гэхэд Төрийн зардал/ДНБ харьцаа ЭЗХАХБ-ын орнуудад 45 хувь хүртэл өсчээ. Төрийн үйл ажиллагааны үүрэг XX зууны турш бүх оронд ингэж өргөжин тэлэхэд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлжээ. Тухайлбал:

1. Дэлхийн хоёр дайны нөлөө
2. “Их хямрал”, түүнийг дагалдсан кейнсийн хувьсгал
3. 1945 оны дараах Зөвлөлт Холбоот Улс тэргүүтэй хөгжлийн социалист загварын нөлөө
4. АНУ болон ЗХУ-ын хоорондын үзэл суртлын глобал өрсөлдөөн ба хүйтэн дайнтай холбоотой цэрэг дайны зардлын өсөлт



Зураг 1. Бодлогын сонголтод үзүүлэх нөлөө

5. Социалист, хүмүүнлэг сэтгэлгээ болон орлогын дахин хуваарилалтаар тэгш байдлыг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулах болсны нөлөө
6. Халамжит төр бүхий капитализмын сэргэлт
7. Эдийн засагчид дам нөлөө, төгс бус мэдээлэл болон нийт эдийн засгийн тогтворгүй байдалтай холбоотой үүсэх зах зээлийн бүтэлгүйтлийг Адам Смитийн анх тодорхойлсноос илүү өргөн хүрээнд авч үзэх болсон явдал.

XX зууны эхэнд эдийн засаг дахь төрийн үүрэг хамгийн бага байв. Гэхдээ та бидний нүдэн дээр өнгөрсөн зуунд эдийн засаг дахь төрийн үүргийн талаарх эдийн засагчдын үзэл бодлын харьцаа ихээхэн өөрчлөгдсөн билээ. XX зууны эхний 75 жил төрийн үүрэг нэмэгдэж байсан боловч сүүлийн 25 жилд энэ хандлага тийм ч хүсээд байх зүйл мөн эсэх талаар эдийн засагчдын сэтгэлгээнд эрс өөрчлөлт гарсан юм. Гэтэл өнөөгийн дэлхийн эдийн засгийн байдал яах аргагүй төрийн оролцоог шаардаж улс орнуудын төр засгийн газрууд эдийн засагт эрчимтэй үүрэг гүйцэтгэж эхлээд байх жишээтэй.

Тэгвэл төрийн үүрэг ямар байх ёстой вэ? Энэхүү асуулт нь бүх л түүхийн туршид төрийн бодлогын асуудлаар хамгийн чухал маргааны талбар болж байв. Түүхийн хуудсыг эргэн харваас зах зээлийн болон төрийн бүтэлгүйтлийн нөлөөг ойлгосон эдийн засгийн шинжилгээний хөгжил ба түүхэн үйл явдал хосолж байж тухайн үеийн төрийн “хил хязгаар”-ыг тогтоож байжээ.


1950, 1960-аад онд зах зээлийн гажуудлыг төр залруулах чадвартай гэдэгт итгэдэг эдийн засагчид хүчээ авч байсан бол, 1970, 1980-аад онд төрийн тэлж буй үүрэгт эргэлзэх хандлага нэмэгдэж, зах зээлд итгэх итгэл эргэн ирсэн юм. Төрийн бүтэлгүйтлийн янз бүрийн хэлбэрийг эдийн засагчид хүлээн зөвшөөрөх болсон. Төр нь нийгмийн сайн санаат төлөвлөгч болж, зах зээлийн бүтэлгүйтлийг засахаар оролцож буй тохиолдолд ч эдгээр стратегийг төлөөлөгчдөөр (хүнд сурталтнуудаар) дамжуулан хэрэгжүүлдэг. Гэтэл эдгээр төлөөлөгч хувийн ашиг сонирхолтой бөгөөд тэднийг хянахад хэцүү байдаг учир засгийн газрын оролцоо нь рент-хайх, авилгалд автах нөхцөлийг бүрдүүлдэг. 1970-аад оноос зах зээл бүтэлгүй юу эсхүл төр бүтэлгүйтээд байдаг уу гэсэн маргаан анхаарал татаж эдийн засгийн зохиол бүтээлд давамгайлах болсон. Питер Бауэр, Милтон Фридман, Жеймс Бьюкенен, Фридрих фон Хайек, Роберт Лукас, Аннэ Кругэр нарын шүүмжлэлийн нөлөөнд автсан олон эдийн засагч төр хэтэрхий ихийг хийхээр оролдож байна гэж үзэх болов. Олон ч оронд төрийн хэт их оролцоо нь зах зээлийн үр ашиг, эдийн засгийн өсөлт, тогтворжилтод сөргөөр нөлөөлж байсан юм. Төр бол “нийгмийн сайн санаат хамгаалагч”, төрийн албан хаагчид бол “өөрийгөө огоорсон түшмэлүүд” гэсэн эргэлзээтэй суурь нөхцөл туршлагаар няцаагдах болсон билээ. Гэхдээ энэ нь капитализм бол төгс систем, зах зээл ямагт үр ашигтай, эсвэл төр ямар ч үүрэггүй гэсэн үг биш. Харин “төр бага төлөвлөж, багыг эзэмшиж, бага зохицуулан, зах зээлийн хил хязгаар өргөжин тэлэхийг зөвшөөрөх” гэсэн утгыг илэрхийлнэ. Зах зээл болон үр ашигтай, хариуцлагатай төр бие биеэ нөхөн гүйцээдэг.

Улс төрчид ба тогтворжуулах бодлого

Макро эдийн засгийн загварт засгийн газрыг эндоген байдлаар илэрхийлэх ёстой гэж улс төрчдийн талаарх “Доунсын” чиглэл үздэг. Мөн уламжлалт кейнсчүүдийн “урсгал эргэлтийн загвар”-т хувиа хичээсэн засгийн газрын үйл хөдлөлийг тусган сайжруулах хэрэгтэй гэж эдийн засагч Фрэй үзсэн. Энэ сайжруулалтын үр дүнд гарч ирэх улс төр-эдийн засгийн системийг зураг 2-т үзүүллээ.

Кейнсийн хувьсгалаас хойш сонгогчид төрд эдийн засгийг даатгах хандлагатай болсон нь эргэлзээгүй. Гэхдээ шийдвэр гаргах эрх мэдлийг хэний гарт төлөөлүүлж бариулахыг сонгохдоо сонгогчид *эзэн-төлөөллийн* бэрхшээлтэй тулгардаг. Учир нь төлөөлөгч (засгийн газар) нь эзнээсээ (сонгогчдоос) өөр сонирхолтой байж болох ба түүнийгээ төгс бус мэдээлэлтэй сонгогчдоосоо нуух боломжтой байдаг.

Зураг 2-т харуулсан улс төр-эдийн засгийн орчил урсгал эргэлтийн загвараас улс төрчид дахин сонгогдох нөхцөл байдал болон үзэл суртлын тэнцвэрээр чиглүүлэгддэг болох нь харагдаж байна. Сонгогчид ажил эрхлэлтийн өндөр түвшин, бага инфляци, бодит орлогын өндөр өсөлт зэрэг эдийн засгийн зорилгод хэр хүрч байгаагаар нь улс төрчдийг үнэлдэг. Сонгуулийн яг өмнөх эдийн засгийн байдал улс төрчдөд онцгой чухал бөгөөд эдийн засаг хөгжиж байвал засгийн газар, эрх баригчид дахин сонгогдоно. Хэрвээ эдийн засгийн нөхцөл байдал таагүйтвэл сонгогчид сөрөг хүчнийг сонгож, эрх баригчид суудлаа алдана. Сөрөг хүчин сонгуулийн сонирхол татахуйц амлалт өгдөг (жишээлбэл, 1988 оны сонгуулийн өмнөх Жорж Бушийн алдарт “Миний уруулыг унш, ямар ч шинэ татвар тогтоохгүй” гэсэн хэлц). Иймээс эдийн засгийн байдал нь сонгуулийн үр дүнд нөлөөлдөг ба мөн сонгогдох гэсэн сонирхол макро эдийн засгийн бодлогын сонголт



Зураг 10.2 Улс төр – эдийн засгийн загвар

ба хэрэгжилтэд ч шууд нөлөөлнө. Улс төрчид намын үзэлд үнэнч байх ёстой. Гэхдээ нам нь ялалт байгуулахгүй, эрх мэдлээ хадгалж үлдэхгүй бол үзэл суртлын хөтөлбөрүүд хэрэгжих боломжгүй. Засгийн газрын нэр хүндэд макро эдийн засгийн гол хувьсагчдын (инфляц, ажилгүйдэл, орлогын өсөлт) үзүүлэх нөлөөг сүүлийн 25 жилийн эмпирик судалгааны ажлуудаар шалгасан. Макро эдийн засгийн эдгээр хувьсагч сонгуулийн үр дүнд нөлөөтэй болох нь статистик шалгуураар батлагддаг. Бодлогын нийлүүлэлт талаас авч үзвэл тухайн үед эрх барьж буй улс төрчид монополий байдалтай учраас дахин сонгогдохын тулд тэвчээр алдаж, дискрет бодлогыг ашиглахад гайхах зүйлгүй.

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд эдийн засагчид дээрх нөхцөл байдлыг тусган, улс төр-эдийн засгийн загварыг олон чиглэлд хөгжүүлжээ. Нийт эдийн засгийн тогтворгүй байдлын шалтгааныг судалдаг эдийн засагчдын судалгааны нэг чиглэл нь улс төр ба эдийн засгийн хоорондох хамаарал болжээ. Эдгээр судалгаа нь дараах сонирхолтой асуултуудад хариулахыг оролддог. Үүнд:

1. Эдийн засгийн хүчин зүйлс сонгогчдын сонголтод хэрхэн нөлөөлдөг вэ? (Schneider, Frey, 1978a, 1978b)
2. Оппортунист буюу ашигч улс төрчид улс төрийн хожоо гаргахын тулд эдийн засгийг гуйвуулдаг уу? (Nordhaus, 1975)
3. Партизан буюу тууштай дэмжигч сэтгэлгээ улс төрийн намуудыг ялгаатай бодлого үйлдвэрлэхэд хүргэдэг үү? (Hibbs, 1977)
4. Рационал, алсын хараатай сонгогч, эдийн засгийн оролцогч бүхий ертөнцөд улс төрийн мөчлөг байж болох уу? (Alesina, 1987; Rogoff, Sibert, 1988)
5. Улс төр-эдийн засгийн загварыг дэмжих эмпирик нотолгоо байна уу? (Alesina, Roubini, Cohen, 1997)
6. Эдгээр загвараас бодлогын ямар зөвлөмж гарах вэ? (Alesina, 1989; Drazen, 2000a)

“Улс төрийн бизнесийн мөчлөг”-ийн өвөрмөц хандлагууд: Тойм

1970-аад оны дундаас хөгжиж эхэлсэн улс төрийн бизнесийн мөчлөгийн онолын бүтээлүүдийг дөрвөн гол хандлагад ангилж болох ба тэдгээр нь тусдаа хоёр үед хуваагдан хөгжжээ. Эдгээр дөрвөн гол ялгаатай хандлагын суурь нөхцөлүүдийг хүснэгт 10.1-д харуулав (Alesina, 1988). Эхний үе буюу 1970-аад оны дунд ба төгсгөл үед Нордхаус энэ салбарын сонирхлыг дахин сэргээж, улс төрийн бизнесийн мөчлөгийн ашигч байдлын загварыг хөгжүүлсэн. Үүний дараа Хиббс албан тушаал хөөцөлдөхөөс илүү намын үзлээр туйлшрах хандлагыг онцолж үзсэн. Гэхдээ Нордхаус болон Хиббсийн загварууд (“хуучин” улс төрийн макроэкономикс) 1970-аад оны хоёрдугаар хагаст макроэкономикст давамгайлж байсан рационал хүлээлтийн хувьсгалын үед олны анхаарлыг төдийлөн татсангүй. Хэсэг хугацааны дараа 1980-аад оны дундуур улс төр-эдийн засгийн загварын хоёрдахь үе гарч ирэн судалгааны энэ чиглэл цэцэглэн хөгжив. Шинэ сонгодог онолчдын нөлөөгөөр эдгээр загварт төлөөлөгч болон сонгогчдыг рационал гэж үзэх болов. Рогофф, Сиберт нар рационал ашигч байдлын загварыг хөгжүүлж байхад (Rogoff,

Sibert, 1988), Алесина рационал бөгөөд тууштай дэмжигчийн онолыг (“шинэ” улс төрийн макроэкономикс) дэвшүүлэв (Alesina, 1987).

Дараагийн хэсэгт бид эдгээр дөрвөн хандлагаас уншигчдадаа зориулан Нордхаусын загварыг тайлбарлан хүргэе. Чухалчлан хэлэхэд дээр дурдсан 4 хандлага бүгд макро эдийн засаг дахь улс төрийн үйл хөдлөлийн нөлөөг эндоген болгох оролдлого байсан юм.

Хүснэгт 1 Эдийн засгийн хэлбэлзлийн улс төр-эдийн засгийн загварууд

Эдийн засгийн оролцогч ба сонгогчийн талаарх суурь нөхцөл		
Улс төрчдийн талаарх суурь нөхцөл	Рационал бус үйл хөдлөл, рационал бус хүлээлт	Рационал үйл хөдлөл, рационал хүлээлт
Тууштай дэмжигч биш, ашигч улс төрч	Нордхаус	Рогофф, Сиберт
Тууштай дэмжигч улс төрч	Хиббс	Алесина

Эх сурвалж: Alesina, 1988

Нордхаусын ашигч байдлын загвар

Улс төрийн бизнесийн мөчлөгийн орчин үеийн зохиол бүтээлүүд Нордхаусын 1975 оны алдарт өгүүллээс эхтэй. Нордхаусын сонгуулийн загварт эрх баригч нам “дараагийн сонгуульд олонх болох зорилгоо биелүүлэх эдийн засгийн бодлого сонгодог”. Сонгуулийн өмнөх макро эдийн засгийн байдал сонгогчдод нөлөөлдөг учраас сонгуулийн үед тааламжтай үр дүнд хүргэх бодлогыг улс төрчид хэрэгжүүлнэ. Энэ үйл хөдлөлийн үр дагаварт ардчилсан зарчмаар хэрэгжүүлж буй бодлого ирээдүй үеийнхний эсрэг чиглэдгээрээ ноцтой юм. Тиймээс сонгууль болон сонгуулийн өрсөлдөөний үеэр засгийн газрын хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлага гардаг ч бодлого боловсруулах үйл явцыг гажуудуулж болзошгүй. Нордхаус хэд хэдэн нөхцөл дэвшүүлэн дээрх үр дүнд хүрчээ. Тэдгээр суурь нөхцөл нь:

- H1. Улс төрийн систем хоёр намаас бүрдэх ба Доунсын дундаж сонгогчийн теорем ёсоор тэдний хооронд бодлогын ижилсэл бүрэн явагдаж яваандаа бодлого нь ялгарахгүй болно.
- H2. Хоёр нам үзэл санааны хөтөлбөр хэрэгжүүлэхээсээ илүү улс төрийн ашгаа л чухалчилна. Намын үзлийг үл ойшоодог, *оппортунист* буюу ашиг хайж явдаг улс төрчдөд зөвхөн сонгуулийн үр дүн л чухал.
- H3. Сонгуулийн хугацаа экзоген, тогтмол.
- H4. Сонгогчид бүгд адил. Тэдний ханамж нийт ажилгүйдэл (U_t), инфляцийн түвшин (\dot{P}_t)-ээс хамаарах бөгөөд эдгээрийг бага түвшинд байхыг илүүд үзнэ.

Бодлого боловсруулагчид сонгогчдын таашаалын тухай бүрэн мэдээлэлтэй боловч ажилгүйдэл, инфляциас хамаарсан таашаалын тодорхой хэлбэрийг мэдэхгүй.

Н5. Сонгогчид тухайн үед засгийн эрхэнд буй улс төрчдийн бий болгосон эдийн засгийн байдалд үндэслэн улс төрийн сонголтоо хийнэ. Сонгогчид *өнгөрснийг хардаг* (ирээдүйгээ хардаггүй) бөгөөд түүх холдох тусам ой санамж нь бүдгэрдэг (өнгөрсөн үеийн эдийн засгийн байдлын талаарх дисконтын түвшин өндөр), өөрөөр хэлбэл, тэд *холын харалган*.

Н6. Хүлээлт агуулсан Филипсийн муруйгаар тодорхойлогдох эдийн засагтай. Богино хугацааны “ацан шалаа”-наас урт хугацааны “ацан шалаа” арай дээр. Сонгогчид макро эдийн засгийн талаар мэдлэг муу.

Н7. Инфляцийн хүлээлт (\dot{P}_t) нь зохицох шинжтэй, өөрөөр хэлбэл, эдийн засгийн оролцогчид өнгөрсөн рүүгээ харж байдаг.

Н8. Бодлого боловсруулагчид мөнгөний болон сангийн бодлогоор нийт эрэлтийг удирдан ажилгүйдлийн түвшинг хянаж чадна.

Бодлогын шийдвэр нь нийт саналын функц (V_t)-д үндэслэдэг гэсэн нөхцөл (Н4)-ийг Нордхаус дэвшүүлсэн. Тэр функц нь хувь хүмүүсийн таашаалаас хамаарч дараах тэгшитгэлээр тодорхойлогдоно.

$$V_t = g(U_t, \dot{P}_t), \text{ энд } g'(U_t) < 0, g'(\dot{P}_t) < 0 \quad (1)$$

Саналын функц нь U_t болон \dot{P}_t -ээс буурах хамааралтай. Нийт саналын функцын (V_1, V_2 гэх мэт) түвшний шугам (ижил-саналын шугам)-ыг зураг 3-т харууллаа. Энэ нь тухайн бодлогын үр дүн дэх сонгогчдын хувийг илэрхийлнэ. Инфляци болон ажилгүйдэл нь “муу үзүүлэлт” тул $V_1 > V_2 > V_3 > V_4$ байна. Сонгогчид V_1 дээрх аливаа цэгийг V_2 дээрх аливаа цэгээс илүүд үзэх боловч нэг түвшний шугамын хувьд аль ч цэгүүд ялгаагүй. Засгийн газар сонгуульд ялахад бүх хүчээ дайчлан, сонгуулийн үед эдийн засгийг хамгийн сайн боломжит түвшний шугамд аваачихыг оролдоно.

Хүлээлт агуулсан Филипсийн муруйгаар тодорхойлогдох, Нордхаусын хэрэглэсэн макро эдийн засгийн бүтцийг (2)–(5) тэгшитгэлд нэгтгэн харуулав. Хүлээлт агуулсан Филипсийн муруй:

$$\dot{P}_t = f(U_t) + \lambda \dot{P}_t^e \quad (2)$$

Адаптив буюу зохицох хүлээлтийн нөхцөл нь:


$$\dot{P}_t^e - \dot{P}_{t-1}^e = \alpha(\dot{P}_{t-1} - \dot{P}_{t-1}^e) \quad (3)$$

Тэнцвэрийн нөхцөл:

$$\dot{P}_t = \dot{P}_t^e \quad (4)$$

Урт хугацааны Филлипсийн муруйн хамаарал:

$$\dot{P}_t = f(U) / (1 - \lambda) \quad (3)$$



Зураг 3 Нордхаусын улс төрийн бизнесийн мөчлөгийн загвар

Нордхаусын $1 > \lambda > 0$ гэсэн суурь нөхцөлөөс урт хугацааны Филлипсийн муруй нь богино хугацааны хамаарлыг бодвол бага таалагддаг (илүү хэвтээ) гэж гарна. Зураг 3-т S_G, S_W, S_M -ээр богино хугацааны муруйг тэмдэглэсэн бөгөөд муруйн байрлал инфляцийн хүлээлтээс хамаарна. Урт хугацааны Филлипсийн муруйг $LRPC$ -ээр дүрсэлсэн. Хэрэв $\lambda = 1$ бол Филлипсийн муруй ажилгүйдлийн зүй ёсны түвшин дээр босоо шулуун болно. Гэвч Нордхаусын үзэж буйгаар, “урт хугацааны босоо Филлипсийн муруйг авч үзлээ гээд загварын үр дүнд зарчмын өөрчлөлт орохгүй” ажээ.

Инфляци ба ажилгүйдлийн оновчтой түвшин

Н4 нөхцөл өгөгдсөн үед бодлого боловсруулагчдын нийгмийн сайн сайхан байдлын функц (W) нь нийт саналын функцийг хугацааны хөнгөлөлтийг тооцсон (цаг хугацааны үнэ цэнийг тооцсон) утгатай тэнцэнэ. Улс төрийн хязгаарлалт байхгүй бол нийгмийн төлөвлөгч (2)–(5) тэгшитгэлээр өгөгдөх макро эдийн засгийн хязгаарлалттайгаар (6) тэгшитгэлээр өгөгдөх сайн сайхан байдлын функцыг хамгийн их байлгана.

$$W = \int_0^{\infty} g(U_t, \dot{P}_t) e^{-rt} dt \quad (6)$$

Шийдвэр гаргагчийн хугацааны хөнгөлөлтийн нормын сонголтоос хамааран хэд хэдэн үр дүн гарч болно. Ирээдүйг өнөөдөртэй адил үнэлдэг ($r = 0$) бол үр дүн нь зураг 3 дээрх G цэгт гарна. Энд $LRPC$ нь нийт санал (V_2)-ын функцийг шүргэгч байх ба тиймээс хамгийн сайн тогтвортой инфляц, ажилгүйдлийн түвшинг

төлөөлнө. Энэ үр дүнг Нордхаус “алтан дүрмийн” бодлогын сонголт гэсэн ба инфляц, ажилгүйдэл нь харгалзан \dot{P}_T, U_G байна. Шийдвэр гаргагчид зөвхөн өнөөдөртөө анхаарал тавьдаг (хугацааны хөнгөлөлтийн норм хязгааргүй) байх “огт алсын хараагүй” бодлогын үр дүнг зураг 3-ын M цэгт харуулав. Энд S_M нь V_4 муруйн шүргэгч байна. Өөрөөр хэлбэл, алсын хараагүй бодлого нь ирээдүй үеийнхний сайн сайхан байдалд санаа тавихгүй учраас алтан дүрмийн бодлоготой харьцуулахад инфляцийн түвшин (\dot{P}_M) өндөр, ажилгүйдлийн түвшин (U_M) бага байна (Nordhaus, 1975). Хэрэв $\infty > r > 0$ бол Нордхаусын “сайн сайхан байдлын ерөнхий оновчлол” гэгдэх үр дүн (W)-д хүрнэ. Энэ тохиолдолд $U = U_W$ ба $\dot{P} = \dot{P}_W$ байна.

Нордхаусын загвар урт хугацаанд

Засгийн эрхэнд байгаа улс төрчид дараагийн сонгуульд гол анхаарлаа хандуулдаг Нордхаусын загвараас “ардчилсан тогтолцоо оновчтой түвшинтэй харьцуулахад бага ажилгүйдэл, өндөр инфляци бүхий урт хугацааны “ацан шалаанд” орсон бодлогыг сонгоно” гэсэн таамаглал дэвшүүлж болно. Энэ үр дүн нь дараах үйл хөдлөлөөс урган гардаг. Сонгуулийн өмнө эдийн засаг зураг 3-ын G цэгт байсан гэе. Тухайн үеийн эрх баригчид эдийн засгийг урамшуулж, богино хугацааны S_G муруйн дагуу E_1 цэгт шилжүүлснээр дараагийн сонгуульд ялах боломжоо нэмэгдүүлнэ. S_G нь V_1 муруйг E_1 цэгт шүргэх учраас засгийн газрын хүрч чадах хамгийн сайн нөхцөл байдал болно. E_1 нь $LRPC$ муруйн зүүн талд байх тул S_G баруун дээш шилжин, хүлээлт нь өндөр инфляцид зохицохыг (3) тэгшитгэл харуулна. Харин сонгуулийн богино хугацааны үр дүн $LRPC$ -н баруун талд байвал тухайн үеийн эрх баригч нам эдийн засгийг $LRPC$ -д буцаан аваачих бодлогын сонголт хийснээр нөхцөл байдлаа сайжруулна. Нордхаусын загвараар, удаа дараагийн сонгуулиар бий болох урт хугацааны динамикийг зураг 4-т харуулав. Энд E_0E_0 нь сонгуулийн үр дүнгийн муруй. E_0E_0 нь $LRPC$ муруйтай огтлолцох $E^*=M$ цэгт урт хугацааны тэнцвэр тогтоно. M цэг нь S_M болон $LRPC$ -н аль алинд харьяалагдах тул “эрх баригч нам богино хугацааны Филипсийн муруйн дагуу шилжиж, нөхцөл байдлаа сайжруулж чадахгүй”. Учир нь S_M нь V_4 муруйг ч бас шүргэнэ (Nordhaus, 1975). Богино хугацааны Филипсийн муруй хэвтээ байх тусам тэнцвэрт төлвийн инфляци өндөр байна.

Загварын урт хугацааны шийд нь алсын хараагүй байрлал M болдог нь сонгуулийн янз бүрийн тогтолцоон дахь ашигч үйл хөдлөлийн сонирхолтой үр дүн юм. Тиймээс ардчилсан тогтолцоотой үед оновчтой түвшинтэй харьцуулахад өндөр инфляц, бага ажилгүйдэлтэй тэнцвэр тогтоно, өөрөөр хэлбэл, инфляцийн хазайлт гарна гэж хэлж болно ($\lambda = 1$ ба Филипсийн муруй босоо үед л инфляцийн хазайлт гардаг)

Богино хугацааны үр дүн: “улс төрийн бизнесийн мөчлөг”

Богино хугацааны үйл хөдлөлийн шинжилгээндээ Нордхаус сонгогчдын ой санамжийг мартамхай (Н5 суурь нөхцөл) байх хувилбарыг авч үзсэн. Өөрөөр хэлбэл, сонгогчид олон сарын өмнөх явдлаас ойрын үеийн үйл явдлыг илүү

чухалчилдаг гэж үзсэн. Энэ тохиолдолд (1) тэгшитгэлийг дараах хэлбэрт (7) бичиж болно.

$$V_t = \int_0^T g(U_t, \dot{P}_t) e^{\rho t} dt \quad (7)$$

Энд T -сонгуулийн мөчлөгийн урт, z -сонгогчдын ой ухааны мартах хурд. Сонгуулийн функцын энэ сайжруулсан хувилбар нь сонгогчид хэдийгээр тухайн үеийн ажилгүйдэл, инфляцийн төлөө засгийн газартай хариуцлага тооцох боловч мартамхай байдал нь ашигч улс төрчдөд сонгогчдыг эртнээс зохион байгуулалттай хуурах боломж олгодог. Богино хугацаанд улс төрийн бизнесийн мөчлөг нь дараах байдлаар өрнөнө. Өмнөхийн адил эдийн засаг эхлээд зураг 3 дахь G цэгт байх үед сонгууль болсон гэж үзье. Засгийн газар нийт эрэлтийг урамшуулан ажилгүйдлийг бууруулж, E_1 цэгт хүрч чадна. Энэ нь G цэгт байснаас илүү олон сонгогчийг татна (өөрөөр хэлбэл, $V_1 > V_2$). Энэ маневрын төлөөсөнд инфляци хурдсана (хүмүүс хүлээлтээ өөрчилснөөр S_G эцэстээ баруун дээш шилжинэ). Гэвч энэ зардал сонгууль явагдсаны дараа гарна. Сонгуулийн яг өмнөхөн инфляци нэмэгдсэн байлаа ч сонгогчид зохицох хүлээлттэй учраас инфляци хурдассаныг ойлгох хүртэл нэлээд хугацаа шаардана. Нэгэнт инфляци өндөр болсон тул засгийн газар түүнийг бууруулах хэрэгтэй болно. Тиймээс сонгуулийн ялалтын дараа засгийн газар нийт эрэлтийг бууруулна, энэ нь ажилгүйдлийг өсгөснөөр инфляцийн хүлээлтийг намжаана. Ингэснээр богино хугацааны Филипсийн муруй буцаж шилжин S_G -д очно. Сонгогчид мартамхай учраас энэ стратеги дараагийн сонгуулиар ахиад л давтагдана. Эртний өвчнөөс саяхны зовиур нь илүү аймшигтай санагдана. Эдийн засгийг зориудаар тогтворгүйжүүлж, улс төрийн бизнесийн мөчлөгийг үүсгэх энэхүү ашигч үйл хөдлөлөөс улс төрчид л хожно. Энэ үр дүн эдийн засгийг тогтворжуулах засгийн газрын үндсэн зорилгын тухай кейнсчүүдийн номлолтой илт зөрчилдөнө.

Нордхаусын загвар нь сонгуулийн мөчлөгийн үеийн ажилгүйдэл ба инфляцийн тухай тодорхой төсөөлөл өгдөг. Сонгуулийн мөчлөгийн эхний хагаст ажилгүйдэл өсөх ба ДНБ буурснаар инфляцийн түвшин буурна. Харин сонгууль дөхөхөд буюу сонгуулийн үеийн хоёрдугаар хагаст ажилгүйдэл буурч, ДНБ өснө. Сонгууль болмогц инфляци огцом өсөх ба хямрал нүүрлэнэ. Нордхаусын энэхүү суурь нөхцөлийг 1947-1972 оны 9 орны өгөгдөл дээр шалгасан бөгөөд “улс төрийн бизнесийн мөчлөг нь зарим капиталист орны эдийн засагт мэдэгдэхүйц нөлөөтэй” гэсэн дүгнэлтэд хүрчээ (Nordhaus, 1975). Эдийн засгийн мөчлөг дэх улс төрийн нөлөөг дан ганц шалтгаанаар тайлбарлаж болохгүй бөгөөд намын үзэл суртал нь улс төрчдийн ашигч үйл хөдлөлийн дараа хоёрдогч нөлөөтэй байгааг хожим Нордхаус баталжээ (Nordhaus, 1989).

АНУ-ын ерөнхийлөгч Ричард Никсоны эхний сонгогдсон хугацааны төгсгөл үеэс ашигч үйл хөдлөлийн жишээг тод харж болно. 1970-1971 оны хямрал нь 1972 оны сонгууль дөхөх үеэр тэлэх бодлогыг маш яаралтай хэрэгжүүлэхэд хүргэжээ. Ерөнхийлөгч Никсон 1972 оны сонгуулийн яг өмнөхөн нийгмийн халамж, тэтгэвэр авагчдад бүгдэд нь нэг захиа хүргүүлжээ (Tufte, 1978). Уг захианд тэтгэвэр авагчийн тэтгэмжийг нь 20 хувиар нэмэгдүүлэх чек бичсэн байв. Ерөнхийлөгч

Эйзенхауэр эдийн засгийг урамшуулах бодлого явуулж чадаагүй учраас түүнийг залгамжлагч Никсон өөрийгөө өмнөх 1960 оны сонгуульд Кеннедид ялагдсан гэж үзэж байв. Иймээс Никсоныг “улс төрийн бизнесийн мөчлөгийн бүх цаг үеийн баатар” гэж тодорхойлсонд гайхах зүйлгүй (Rogoff, 1988).

Энэ үзэгдлийн ноцтой дутагдлыг эмчлэх боломжтой хэд хэдэн хувилбарыг Нордхаус санал болгосон. Тухайлбал, сонгогчдын мэдээллийн боломжийг нэмэх, хараат бус төв банкны мөнгөний бодлого хэрэгжүүлэх зэргийг дурдаж болно.

Загвардын уналт, сэргэлт

Тогтвортой бага инфляци, бага ажилгүйдэл, өндөр хурдтай өсөлт бүхий капиталист ертөнцийн “алтан үе” 1970-аад онд төгсгөл болов. 1970-аад оны стагфляци нь дэлхийн хоёрдугаар дайнаас хойшхи 30-аад жилд макро эдийн засгийн онол ба бодлогод давамгайлж байсан кейнсчүүдийн ноёрхлыг төгсгөл болгов. Монетарист сөрөг хувьсгалын дуунаар Лукас рационал хүлээлтийн хувьсгалыг эхлүүлэв. 1970-аад оны дундуур зохицох хүлээлтийн таамаглалыг хэрэглэж байсан загварууд шинэ сонгодог онолчдын хүчтэй шүүмжлэлд өртөх болов. Рационал хүлээлттэй, зах зээл тасралтгүй тэнцвэрждэг загварт бодлого боловсруулагчид бодит эдийн засагт нөлөөлөхөд нь ирээдүйгээ хардаг эдийн засгийн оролцогчид төвөг учруулдаг. Тиймээс бодлого боловсруулагчдын ашиглаж болох богино хугацааны Филлипсийн муруй гэж байхгүй. Жишээлбэл, сонгуулийн өмнөх мөнгөний тэлэлтийг рационал оролцогчид урьдаас мэдэж байгаа учраас тэр бүр почирдохгүй.

Түүнчлэн рационал хүлээлтийн таамаглалаар сонгогчид ирээдүйгээ хардаг ба системтэй алдаа хийдэггүй гэж үздэг. Рационал хүлээлтийн онолын “сүйрүүлэгч” шүүмжлэлээс болоод улс төрийн бизнесийн мөчлөгийн онолд Нордхаус, Линдбек, Макрэй нарын хойш дорвитой дэвшил гараагүй гэж Алесина бичжээ. Нордхаусын загвар нь богино хугацааны Филлипсийн муруй болон алсын хараагүй сонгогчдыг хамтад нь авч үздэг. Харин рационал хүлээлтийн таамаглал гарч ирснээр улс төрчид сонгуульд оноо авахын тулд эдийн засгийг ашиглахаар сонирхдогийг сонгогчид мэднэ гэж үзэх болсон. АНУ-ын ерөнхийлөгчийн сонгууль дөрвөн жил тутам явагддаг журамтай учраас рационал сонгогчид болон эдийн засгийн оролцогчид хувийн ашиг сонирхолдоо хөтлөгдсөн улс төрчдийн эдийн засгийн заль мэхэд байнга хууртана гэж итгэхэд бэрх. Түүнээс гадна эрх баригчдын сонирхолд нийцсэн мөнгөний бодлого хэрэгжүүлэхийг засгийн газраас төв банкинд шахаагүй л бол бие даасан төв банк мөнгөний бодлого явуулдаг нөхцөл байдал бүхий Нордхаусын загварыг хүлээн зөвшөөрөхөд хэцүү юм. Гэсэн ч Блайндер өөрийг нь 1994-1996 онд Холбооны Нөөцийн дэд тэргүүн байх үед нь улс төрийн дарамт байгаагүй гэж хэлсэн билээ. Хэдийгээр түүний үед улс төрөөс мөнгөний бодлогод ирэх дарамт “тун ялихгүй, бараг тэг” байсан боловч, Ричард Никсон-Артур Бирны үед харин ийм дарамт байсан гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Улс төрийн бизнесийн мөчлөгийн бүтээлүүд эхэн үедээ онолын хувьд ийм сул талтай байснаас гадна Нордхаусын загвар гэхэд эмпирик судалгааны зүгээс хүчтэй дэмжлэг авч чадаагүй юм (Mullineux et al., 1993). АНУ-ын өгөгдөл дээр Нордхаусын загвар тохирохгүй байсан бол ЭЗХАХБ-ын орнуудын хувьд улс

төрийн бизнесийн мөчлөгийн сулхан нотолгоо л олджээ. Бусад судалгаагаар АНУ болон ЭЗХАХБ-ын орнуудын ажилгүйдэл ба ҮНБ-ий өсөлтийн өгөгдөлд улс төрийн бизнесийн мөчлөг байгаа нь тун сул мэдрэгддэг. Сонгууль явуулах хугацаа эндоген тохиолдолд мөн Нордхаусын загварыг хэрэглэдэг (Alesina et al., 1993). Харин өөр хэдэн судалгаагаар нэлээд нааштай үр дүн гарчээ. АНУ-д сонгуулийн өмнө сангийн болон мөнгөний бодлогоор манипуляц хийгддэг зарим нотолгоог эдгээр судалгаа харуулжээ. Үүнээс гадна, сонгуулийн дүнг бодлогын үр дүнд (инфляци, ажилгүйдэл, өсөлт гэх мэт) үндэслэж таамаглах, бодлогын арга хэрэгсэлд (татвар, засгийн газрын зардал, зээлийн хүү гэх мэт) үндэслэж таамаглахын ялгааг Дрэйзен тодруулаад, “макро эдийн засгийн үр дүнгээс илүүтэй макро эдийн засгийн бодлогоос ашиг хонжоо гаргах манипуляц хийгддэг” гэж дүгнэсэн (Drazen, 2000a). Бодлогын үр дүнгийн талаас аваад үзвэл, сонгуулийн өмнөх бодит ДНБ болон ажилгүйдлийн өөрчлөлтөөс илүүтэй сонгуулийн дараах инфляцийн төлөв байдлаас улс төрийн бизнесийн мөчлөгийн ашигч байдлын онолыг дэмжсэн нотолгоо ажиглагддаг. Харин бодлогын арга хэрэгслийн талаас аваад үзвэл, мөнгөний бодлогоос илүүтэй сангийн бодлогод манипуляц хийгддэг ажээ.

1980-аад оны дундуур улс төрийн эдийн засгийн зохиол бүтээлд шинэ түрлэг гарав. Бизнесийн мөчлөгийн талаарх бүтээлүүдийг Зарнович судлаад, дээрх загварууд дэмжих нотолгоо хангалтгүйгээс гадна суурь нөхцөл нь “эргэлзээтэй”, “чанга” байдаг гэж сонгуулийн мөчлөгийн тухай нэгэн зүүлт тайлбартаа шүүмжилжээ. Гордоны эмхтгэсэн *Америкийн бизнесийн мөчлөг* хэмээх шүүмж судалгаанд ч бас ийм үл ойшоосон өнгө харагддаг (Gordon, 1986).

Хэсэг хугацаанд үл тоогдон нам гүмхэн байсан улс төр ба макро эдийн засгийн хоорондын хамаарлын тухай судалгаа 1980-аад оны дунд үеэс эрс сэргэж эхлэв. Эдийн засагчид рационал улс төр-эдийн засгийн загварын шинэ үеийг гаргаж, рационал хүлээлтийн шүүмжлэлд хариу барив. 1970-аад оны эхэн үетэй адилаар, улс төр-эдийн засгийн загварын хоёр дахь үе нь улс төр, макро эдийн засгийн хоорондох хамаарлын тухай ашигч болон тууштай дэмжигчийн хувилбараас бүрдэж байв. Дараагийн хэсэгт рационал улс төрийн бизнесийн мөчлөгийн загварын гол онцлогийг авч үзэх болно.

Рационал улс төрийн бизнесийн мөчлөг

Бодлого боловсруулагчид ба сонгогчдын хооронд мэдээлэл тэгш бус байх рационал хүлээлтийн загваруудад ч Нордхаусын загварын зарим санааг тусгаж болохыг улс төрийн бизнесийн мөчлөгийн сүүлийн үеийн судалгаа харуулдаг. Өөрөөр хэлбэл, сонгогчид нь алсын хараагүй үед л улс төрчид улс төрийн бизнесийн мөчлөг үүсгэдэг байх албагүй. Улс төрчид, сонгогчид, эдийн засгийн оролцогчдын хооронд тэгш мэдээлэлтэй, нийгмийн зорилгын талаар санал нэгдмэл байх улс төрийн өрсөлдөөнт орчинд л оновчтой бодлого дэвших боломжтой. Гэтэл эдгээр нөхцөл тэр бүр биелэхгүй учраас улс төрчдийн ашигч үйл хөдлөл оновчгүй бодлогыг төрүүлдэг. Ирээдүйгээ хардаг сонгогчид эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлын талаарх бүрэн мэдээллээр хангагдахгүй байх төгс бус мэдээллийн зарим нөхцөлийг

харгалзвал эрх баригчид сонгуулиас хожоо гаргахын тулд ашигч үйл хөдлөлөөр “түр зуурын хөгжил цэцэглэл” бий болгох боломжтой болдог (Alesina, 1989).

Зарим судлаачийн дэвшүүлсэн рационал ашигч загварт сонгуулийн мөчлөг нь засгийн газрын зардал, татвар, мөнгөний өсөлт зэрэг бодлогын хувьсагчдаас үүсэх ба тэр мөчлөг нь мэдээллийн түр зуурын тэгш бус байдлаас шалтгаалах боломжтой ажээ (Cukierman, Meltzer, 1986; Rogoff, Sibert, 1988; Rogoff, 1990; Persson, Tabellini, 1990). Хэдийгээр рационал сонгогчид ханамжийг нь хамгийн их байлгана гэж итгэж байгаа улс төрчдийг сонгох зорилготой ч, өрсөлдөж буй бодлого боловсруулагчдын талаарх мэдээлэл хомс байдаг. Сонгогчид үр дүнг харж байж л эрх баригчдын чадал чансааны тухай мэдээлэлтэй болно. Тиймээс эрх баригчид өөрсдийгөө чадвартай гэж үнэмшүүлэхийн тулд сонгогчдод “дохио өгнө”. Ийм дохио Их Британид сангийн сайдын жил тутам хийдэг төсвийн танилцуулгын үеэр, ялангуяа сонгуулийн яг өмнөх жил тод ажиглагддаг.

Рогофф, Сиберт нар улс төрчийн чадварыг төсвийн үргүй зардлыг бууруулах чадамж гэж тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, чадамжтай засгийн газар тухайн татварын орлогоор илүү их нийгмийн бараа, шилжих төлбөр нийлүүлнэ. Эрх баригчид сангийн түр зуурын урамшууллыг нэмэгдүүлэх (эсвэл зайлшгүй шаардлагатай байсан татварыг зогсоох) эрх мэдэлтэй. Энэ нь сонгогчдод таалагддаг. Төсөв боловсруулах нь төвөгтэй үйл явц учраас сонгуулийн дараах татварын өсөлтөөр сонгуулийн өмнөх элдэв урамшууллыг санхүүжүүлнэ гэдгийг рационал сонгогчид ч бүрэн бус мэдээллийн улмаас урьдчилан харж чаддаггүй. Ажилгүйдэл-инфляцийн зүй тогтолтой мөчлөг үүсдгийг тайлбарлах Нордхаусын загвараас ялгаатай нь рационал улс төрийн бизнесийн мөчлөгийн онол сонгуулийн өмнө болон дараа бодлогын хэрэгслүүдээр манипуляц хийнэ гэж үздэг. Сонгуулийн өмнө татварыг бууруулж, зарлагыг өсгөн чадвартайгаа харуулах гэсэн эрх баригчдын увайгүй шохоорхол эдийн засгийг оновчтой байдлаас илэрхий холдуулдаг. Хэдийгээр рационал ашигч байдлын загварууд Нордхаусын анхны загвартай харьцуулахад эмпирик таамаглалын янз бүрийн боломжийг гаргаж ирдэг ч уг загварт рационал ашигч үйл хөдлөл чухал байр суурьтай хэвээр байна. Тухайлбал, рационал хүлээлтийн улмаас сангийн болон мөнгөний бодлогын манипуляцийн үр дүнд бий болох ямар ч мөчлөгийг богино хугацаатай, зүй тогтолгүй болно гэж таамагладаг.

Эцэст нь, хөгжиж буй орнуудын засгийн газар ч өндөр хөгжилтэй орнуудын засгийн газартай адил үйл хөдлөлтэй байдгийг тэмдэглэх хэрэгтэй. Хэдийгээр нээлттэй эдийн засагт хувийн ашиг сонирхол хөөсөн улс төрийн үйл хөдлөл бага байдаг ч сонгуулиас үүсэлтэй сангийн бодлогын мөчлөг “мэдэгдэхүйц хэмжээнд” байдгийг Шукнект хөгжиж буй 35 орны судалгаагаар тогтоожээ (Schuknecht, 1996).

Дүгнэлт

1980-аад оны сүүл үеэс эхлэн орчин үеийн эдийн засгийн шинжилгээний аргуудыг хэрэглэсэн улс төрийн эдийн засгийн дахин сэргэлт болж байна. Энэхүү “шинэ улс төрийн эдийн засаг”-ийн судлаачдын нийтлэг зорилго нь экономиксийн гол чиглэлд улс төрийн үйл явцыг нэгтгэх шаардлага юм. 1970-аад оны дунд үед

Нордхаусын нөлөө бүхий бүтээл нь Шумпитэр, Калецки нарын үзэл санаанаас эхтэй улс төрийн бизнесийн мөчлөгийг сонирхох судлаачдын сонирхлыг дахин сэрээсэн билээ. Гэвч рационал хүлээлтийн хувьсгал гарсны дараа улс төр-эдийн засгийн загваруудыг сонирхох нь нэг хэсэгтээ намжсан. Рационал бус, ашигч, тууштай дэмжигчийн загварын онолын сул тал ба туршлагын үр дүнгийн эргэлзээтэй байдал нь судалгааны энэхүү талбарыг түр зуур намжихад хүргэжээ. Туршлагын тухайд Оолт, Кристал нар “дэмжих нотолгоо хангалтгүй байдгийг ойлгохгүйгээр улс төрийн бизнесийн мөчлөгийн зохиолыг хэн ч уншиж чадахгүй” гэж зарлав. (Alt, Chrystal, 1983). Улс төр-эдийн засгийн хандлагыг сонирхох нь багассан үед шинэ сонгодог онолчид рационал хүлээлттэй зах зээлийн тэнцвэрийн загварын бодлогын дүгнэлтийг гүйцээх гээд тун завгүй байв. Энэ загваруудад бодлогын үр ашиггүй байдал болон рационал чанарыг онцлохдоо улс төрийн сэдэлтэй бодлогын манипуляцаас болоод бодлого тууштай бус болдог гэж анхнаасаа тайлбарлаж байв. Гэсэн хэдий ч тэгш бус, төгс бус мэдээлэл, нэгдсэн журмаар байгуулаагүй нэрлэсэн цалингийн гэрээ, сонгуулийн үр дүнгийн тодорхой бус байдал зэрэг онцлогийг тусгасан шинэ рационал улс төр-эдийн засгийн загварууд амжилттай хөгжиж байв. Нийгмийн сайн сайхан аж байдлыг аль болох дээшлүүлэхийн тулд эдийн засагчдын зөвлөгөөг авч буй өгөөмөр дарангуйлагч бодлого боловсруулах үйл явцыг тодорхойлохгүй. Харин өөр өөр сонирхол бүхий янз бүрийн өрсөлдөгч бүлгүүдийн тоглох нарийн төвөгтэй тоглоомоор бодлого боловсруулах үйл явц тодорхойлогдоно.

Аж үйлдвэржсэн ардчилсан орнуудад нийт эдийн засгийн тогтворгүй байдал үүсэхэд улс төр хэр нөлөөлөх нь нэлээд маргаантай байгаа ч сонгуулийн ердийн мөчлөгтэй тулгарсан улс төрчид холыг биш ойрыг л харах хандлагатай болдог гэсэн санааг үгүйсгэх хүн цөөхөн болов уу. Дахин сонгогдох, эсвэл албан тушаалдаа үлдэх гэсэн хүсэл нь улс төрчдийг нийт эдийн засгийн тогтворгүй байдал үүсгэхүйц эдийн засгийн бодлого хөөцөлдөж, амлахад хүргэдэг. Хэрэв энэ үндэслэлийг хүлээн зөвшөөрч байгаа бол тэгээд юу хийх шаардлагатай вэ? Урт хугацааны зорилгод нийцсэн эдийн засгийн тогтвортой бодлогыг түлхүү хэрэгжүүлэхэд ээлтэй орчин бүхий институцийн хүрээг бүрдүүлэх шаардлагатай. Ардчилсан төрийн суурь зарчмыг хөндөхгүйгээр, институцийн шинэтгэл хийх замаар улс төрчдийн богино хугацааны хэт улайрсан дур зоргын үйл ажиллагааг хэрхэн хязгаарлах вэ гэдэг нь аж үйлдвэржсэн ардчилсан орнуудад тулгардаг зангилаа асуудал юм. Энэ асуудлыг шийдэх оролдлого нь эдийн засгийн болон сонгуулийн мөчлөгийн хоорондын хамаарал макро эдийн засагчдын судалгааны үржил шимт талбар хэвээр үлдэх нөхцөлийг хангаж байна.

Эдийн засагчид загвартаа улс төрийн хэмжээсийг нэмснээр зөвхөн нийт эдийн засгийн тогтворгүй байдлын талаарх бидний ойлголтыг нэмэгдүүлээд зогсоогүй. Тэд бас өсөлтийн гайхамшиг болон сүйрлийн илүү гүнзгий шалтгааныг эрж хайсан юм. Ингэснээр тэд эдийн засгийн өсөлт “муу” институц, “муу” бодлогоос болж хязгаарлагддагийг илрүүлсэн. Сүүлийн үеийн судалгаанууд нь эдийн засгийн өсөлт, хөгжлийн талаарх улс төрийн эдийн засгийн онолыг шинэ үзэл санаагаар баяжуулсан улс төр судлал, эдийн засгийн ухааны харилцан үйлчлэлийг судалж, үндэстний хэмжээнд одон улсын эдийн засгийн интегран хэрхэн нөлөөлж буйг

шинжлээд байна. Эдгээр нь улам сайн судлаж шинжлэх шаардлагатай талбар гэдэг нь тодорхой. Улс төрийн шинжлэх ухааны судлаачид эдийн засгийн хүчин зүйлсийг орхигдуулж болохгүйн адил эдийн засгийн бодлогын позитив загварыг сонирхож буй эдийн засагчид “улс төрийн хүрээг орхигдуулж болохгүй, тэгэх ч ёсгүй” гэдэг нь тодорхой болоод байгаа тул бид улс төрийн эдийн засаг гэсэн нэрнээс цэрвэхээ больж судалгаа шинжилгээгээ энэ чиглэл рүү хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай болжээ.

Ашигласан ном зүй.

B. Snowdon and H. Vane, “Modern Macroeconomics: Its Origins, Development and Current State”, Edward Elgar Publishing Inc., 2005